ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 09 сарын 19 өдөр Дугаар А/26 Модот

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 5.1 заалт, Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 208 дугаар "Зөвшөөрөл олгох тухай" тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Малын үржил, бүртгэл мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэх, нэгдсэн санд бүртгэхийг Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн (И.Найманцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 28 -ны өдрийн А/05 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА Ү.ИЧИНХОРЛОО

Хөтлөх хэргийн 26 C: /My Documents/ tusaal/

2325060042